


ХЯНАЛТЫН КАРТ-33

1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31 ¹																														
Баримт бичгийн мэдээлэл																														Удирдлагын заалт, цохолт
Нэр төрөл	Хүлээн авсан он, сар, өдөр, бүртгэл ийн дугаар	Хаанаас, хэнээс	Хаана, хэнд	Он, сар, өдөр, бүртгэл -ийн дугаар	Товч утга																									
1	2	3	4	5	6																									
Тушаал	2025.08.05 №33	ЦУОШГ-ын дарга Э.Баттулга	ДУА-н УЦУОШТ-ийн дарга С.Алтанполгион	2025.08.04 A/162	Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээн ий төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай	  																								

Баримт бичгийн шийдвэрлэлт				ХХНЖ-ын хэргийн индекс
Шийдвэрлэсэн нэгж, ажилтан	Шийдвэрлэх хугацаа	Шийдвэрлэсэн хугацаа	Шийдвэрлэсэн тухай тэмдэглэл, баримт бичгийн он, сар, өдөр, бүртгэлийн дугаар	
8	9	10	11	12



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

Аймаг, хотын Ус цаг уур, орчны
шинжилгээний төвийн дүрэм,
бүтэц, орон тооны хязгаар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын харьяа аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, бүтэц, орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын "Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дүрэм, зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч батлах тухай" 2016 оны А/129, "Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай" 2019 оны А/83, "Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай" 2023 оны А/83 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА

151250453

Цаг уур, орчны шинжилгээний газрын
даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны
өдрийн 4/14 тушаалын 01 дүгээр хавсралт

АЙМАГ, ХОТЫН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ус цаг уур, орчны шинжилгээний төв (цаашид "Төв" гэх) нь тухайн аймаг хотын нутаг дэвсгэрт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн, удирдлагаар хангах, ус, цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээг зохион байгуулж, төлөв байдлыг үнэлэх, төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага мөн.
- 1.2. Төв нь Монгол Улсын "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай", "Агаарын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Төрийн албаны тухай", "Төсвийн тухай", "Хөдөлмөрийн тухай" хуулиуд болон төрийн үйлчилгээний байгууллагын хүрээнд дагаж мөрдөх холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм, журмуудыг удирдлага болгон ажиллана.
- 1.3. Төвийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагаас томилсон дарга удирдаж, үйл ажиллагааныхаа талаар удирдах дээд байгууллагын өмнө хариуцлага хүлээнэ.
- 1.4. Төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 1.5. Төвийн дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал шийдвэр гаргаж биелэлтийг ханган, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.
- 1.6. Төвийн даргын дэргэд түүнд зөвлөх үүрэгтэй Зөвлөл ажиллуулж болох бөгөөд зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг төвийн даргын тушаалаар баталж ажиллуулна.
- 1.7. Төвийн дарга нь жил бүр Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.
- 1.8. Төв нь хуулийн этгээдийн хувьд тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлгэдэл тэмдгийг хэрэглэх ба харилцах данстай байна.

Хоёр. Төвийн эрхэм зорилго

Нутаг дэвсгэрийн хэмжээнд ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ, ажиглалт хэмжилт хийж, бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгаль, цаг агаарын болзошгүй аюултай, гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэхэд оршино.

Гурав. Төвийн үйл ажиллагааны чиглэл

Төв нь дараах үндсэн чиг үүрэгтэй ажиллана.

- 3.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгж, ажилтныг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;
- 3.2. Ус цаг уур байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр улс, аймаг, хотын төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хангах;
- 3.3. Ус цаг уур, байгаль орчны зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах;

Дөрөв. Төвийн даргын эрх, үүрэг

- 4.1. Төвийн дарга нь дараах эрхтэй.
 - 4.1.1. Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд бусад байгууллага, иргэдтэй гэрээ хэлцэл хийх;
 - 4.1.2. Орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажилд шинэ арга зүй, техник, технологи нэвтрүүлэх талаар удирдах дээд байгууллагад санал оруулах;
 - 4.1.3. Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;
 - 4.1.4. Албан хаагчдыг хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах;
 - 4.1.5. Төвийн болон харъяа ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгж, ажилтнуудын ажлыг дүгнэх, тайланг хэлэлцэх, шагнаж урамшуулах, төрийн дээд шагнал болон бусад шагналд тодорхойлох;
 - 4.1.6. Аймаг, нийслэлийн төр захиргааны байгууллагаас Монгол Улсын "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажил болон ус, цаг агаарын урьдчилсан мэдээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргэх үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөгөө өгөх;
 - 4.1.7. Ус цаг агаарын гамшигт үзэгдэл, түүнээс учирсан хохирлын тухай албан ёсны тодорхойлолт, тооцоо судалгааг дүүрэг, баг, хорооны Засаг дарга нараас гаргуулан авах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх;
 - 4.1.8. Төв нь хариуцсан нутаг дэвсгэртээ ус цаг уур, орчны төлөв байдлын өөрчлөлт, агаар, хөрс, ус, цацраг идэвхийн түвшний хяналт шинжилгээ эрхэлдэг мэргэжлийн байгууллагын хувьд хяналт шинжилгээний үр дүнгээр дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар байгууллага, иргэдэд шаардлага тавих, хамтарч ажиллах.
- 4.2. Төвийн дарга нь дараах үүрэгтэй.
 - 4.2.1. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ус цаг уур, орчны чанарын

- хяналт шинжилгээний ажлыг батлагдсан хөтөлбөр, заавар журмын дагуу гүйцэтгэх, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;
- 4.2.2. Төвийн харъяа ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгж, ажилтнуудын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний өдөр тутмын ажилд хяналт тавих, шалган зааварлах, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу өртөө, харуулуудыг шинээр байгуулах, шинэчлэн төхөөрөмжлөх, нүүлгэн шилжүүлэх, татан буулгах;
- 4.2.3. Төвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг удирдах дээд байгууллагад гаргаж өгөх;
- 4.2.4. Өртөө, харуулуудын ажиглалт, шинжилгээний материалд техник, шүүмж шалгалт хийж баталгаажуулах, хариу зааварчилгаа өгөх, шинжилгээний материалаар зохих журмын дагуу мэдээллийн архив, цахим сан бүрдүүлэх;
- 4.2.5. Шинжилгээний ажлын хөтөлбөрийг үндэслэн шаардлагатай багаж, төхөөрөмж, сэлбэг материалыг төвлөрсөн хангамжаас захиалан авах, хуваарилах, ашиглалт, зарцуулалтад нь хяналт тавих, хэмжих хэрэгслийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтоосон хугацаанд хийлгэх, шалгалт сорилын баталгаажуулалтад оруулж хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах;
- 4.2.6. Зохих журмын дагуу боловсруулсан төсөл буюу удирдах дээд байгууллагаас өгсөн үүргийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажил хийх;
- 4.2.7. Аймаг, хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа ус цаг уур, орчны чанар, /бохирдуулах эх үүсвэрийн тооллого/, хяналт шинжилгээний ажил, түүний үр дүн, төлөв байдлын талаар дүгнэлт гаргах, холбогдох байгууллага, иргэдэд зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, сурталчлах, ус цаг уур, орчны мэдээ, мэдээллийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр үйлчилгээний ажлын хүрээг өргөтгөх;
- 4.2.8. Аймаг, хотын Засаг даргад ажлаа танилцуулж, удирдамж, туслалцаа авч ажиллах, "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль"-иар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгч ажлаа уялдуулан зохион байгуулах;
- 4.2.9. Мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, мэргэжил, мэдлэгийг нь дээшлүүлэх, ажиллагсдын ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 4.2.10 Төвийн үндсэн хөрөнгийн ашиглалт, санхүү, аж ахуйн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийг стандартад нийцүүлэн хөтлөх, санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах.

Тав. Төвийн төсөв, санхүүжилт

- 5.1. Төвийн үйл ажиллагаа нь улсын төсвөөс санхүүжнэ.
- 5.2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөл, хөтөлбөр, нэмэлт үйл ажиллагаа болон мэдээллийн үйлчилгээнээс орлого олж болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 8 дугаар сарын 04-ны өдрийн 4/ тушаалын 2 дугаар хавсралт

Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн бүтэц, орон тооны хязгаар

№	Төвийн нэр	Батлагдсан орон тоо	Төвийн дараа	Ерөнхий технологийн инженер бөгөөд бараг хамжилгауй хариуцсан технологийн инженер	Урьдчилан мэдээлэхийн технологийн инженер	Урьдчилан мэдээлэхийн инженер	Нисэх буюу технологийн техникч	Өртөөний ахлах техникч, инженер	Цаг уурын өртөөний техникч	ХАА-н цаг уурын харуулын техникч	300 цаг уурын харуулын ажиглагч	Агро цаг уурын инженер	Цаг уурын технологийн инженер	ХАА-н цаг уурын технологийн инженер	Цаг уур, ХАА-н цаг уурын ахлах техникч,	Усны харуулын ажиглагч	Ус судлалын технологийн инженер	Усны ахлах техникч, инженер	Мөстөл судлалын технологийн инженер, ус судлалын инженер	Аэрологийн технологийн инженер	Аэрологийн техникч+газ генераторч	Холбоо сүлжээний ерөнхий инженер	ЦАЭН ерөнхий инженер	ЦАЭН техникч, жолооч,	БОШ-ийн технологийн инженер	БОШ-ийн инженер	Мэдээллийн сангийн ерөнхий зохицуулагч	Нягтлан бодогч	Нарав+ байгууллагын архив	Хүний нөөц+бичиг хэрэг	Үйлчлэгч
1	Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	63	1	1	1	3	4	16	13			1	1	1	1	10	1				1	0.5	1	1	2	0.5	1	1	1	1	1
2	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	85	1	1	1	3	9	36	10			1	1	1	1	10	1				1	0.5	1	1	2	0.5	1	1	1	1	1

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	
3	Баян-Өлгий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	75	1	1	1	4	3	6	24	6		1	1	1	1	13	1	1	1			1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
4	Булган аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	78	1	1	1	4	1	6	24	10	3	1	1	1	1	12	1	1				1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
5	Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	76	1	1	1	4	2	6	24	14		1	1	1	2	5	1		0.5	1	2	1	0.5	1	1	1	1.5	0.5	1	1	1	1
6	Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	65	1	1	1	4	2	5	20	10		1	1	1	1	8	1					0.5	0.5	1	1	1	1.5	0.5	1	1	1	1
7	Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	58	1	1	1	3		6	24	8	1	1	1	1	1							1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
8	Дундговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	59	1	1	1	4		6	24	8		1	1	1	1	1						1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
9	Завхан аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	92	1	1	1	4	2	8	32	15		1	1	1	2	12	1	1				1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
10	Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	80	1	1	1	4		7	28	11		2	1	1	1	7	1			1	2	1	0.5	1	1	1	3	0.5	1	1	1	1

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	
11	Өмнөговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	64	1	1	1	4	3	6	24	8			1	1	1					1	2	1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
12	Сүхбаатар аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	49	1	1	1	3	4	16	9			1	1	1	1	1						1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
13	Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	71	1	1	1	3	7	28	6			1	1	1	1	10	1					1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
14	Төв аймаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	95	1	1	1	3	11	44	10	3		1	1	1	2	6	1					1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
15	Увс аймаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	81	1	1	1	4	2	7	28	10		1	1	1	1	9	1	1	1	1	2	1	0.5	1	1	1	2	0.5	1	1	1	1
16	Ховд аймаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	87	1	1	1	4	3	9	36	7		1	1	1	1	10	1		1			1	0.5	1	1	2	0.5	1	1	1	1	1
17	Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	112	1	1	1	4	3	11	44	13		1	1	1	2	15	1	1		1	2	1	0.5	1	1	2	0.5	1	1	1	1	1
18	Хэнтий аймаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	79	1	1	1	4	1	8	32	10		1	1	1	1	7	1					1	0.5	1	1	2	0.5	1	1	1	1	1

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32
19	Улаанбаатар хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	43	1	1				4	16	2			1	1	1	7	1			1	2	0.5					0.5	1	1	1	1
20	Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	14	1	0.5	1	1			4				1									0.5	0.5	1	1		0.5	1	1		
21	Дархан-Уул аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	32	1	1	1	1		1	8	2		1.5	1			3	1					0.5	0.5	1	1	3	0.5	1	1	1	1
22	Орхон аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	19	1	0.5	1	1			4	1			1									0.5	0.5	1	1	2	0.5	1	1	1	1

-----000-----

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
ХТ06054

Бүртгэсэн № 33 карт № 33
Огноо 2025.08.05
14 цаг 00 минутанд
Дулаагч
ирсэнийг бүртгэв.

Р.И.М.М.М.